



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 11 өдөр

Дугаар А/59

Сүхбаатар сум


### Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.16, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.1, 13.2.3, 13.2.10 тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжих “Ногоон байгууламжийн усалгааны систем (Сэлэнгэ, Сүхбаатар сум)” ажлын тендер шалгаруулалтыг зохион байгуулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга	П.Эрдэнэсайхан (Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга)
Гишүүд	С.Жавзанжамба (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ- үнэлгээний хэлтсийн мэргэжилтэн)
	Г.Хонгор (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн)
	Д.Золбаяр (Сүхбаатар сумын иргэний төлөөлөл) тохиролцсоноор
Нарийн бичгийн Дарга	Д.Ариунтуул (Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

2.Дээрх ажлын хэсгийн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж, халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиж, хууль журмын дагуу зохион байгуулж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга (П.Эрдэнэсайхан)-д даалгасугай.



C:\users\albanbichig2021\zahiramjA4.docx

430810127



Боловруулсан: .....
Хянасан: .....
Хувь: .....

